

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГА  
БОЛДБААТАРЫН НАРАНБАДРАХЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
<b>Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”</b>							
1.	Албаны эрэлч нохойн амьдрах, сургах орчин нөхцөлийг сайжруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээ р, тоогоор	-	-Нохойн хоолны судалгаа хийж, холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж, эрэлч нохдыг зориулалтын хоолоор хангах ажлыг эхлүүлнэ. -4 эрэлч нохойгоор гаалийн газар, хороодод нөхөн хангаль хийсэн байна.	- ГЕГ-ын даргын 2024 оны 03 сарын 22-ны өдрийн № А/185 тоот “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвийн албаны эрэлч нохойд зориулалтын хоол нийлүүлэх харьцуулсан тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах зорилготойгоор зохион байгуулагдсан. 2024.04.05-ны өдөр ГЕГ/20240202002/02/01 урилгын дугаартай тендерийг зарласан. Уг тендэрт шаардлага хангасан аж ахуй нэгж компани байгаагүй учир цуцалж 2024 оны 04.17-ны өдөр ГЕГ/20240202002/03/01 урилгын дугаартай тендерийн сонгон шалгаруулалтанд “Az болор мөнх трейд” ХХК материал шаардлага хангагдан сонгогдсон. 2024.05.15-	01.01- 06.05	80

ны өдөр Эрэлч нохойн сургалтын төвд 10 тонн нохойн хоол нийлүүлсэн. Гаалийн байгууллагын эрэлч нохойн хоолны хэрэгцээнд зориулж Харьяа гаалийн газар хороодод тарааж эхэлсэн.

- 2024 оны эхний хагас жилийн байдлаар ГЕГ-н даргын 2024.01.31-ны өдрийн Б/68 тоот тушаалаар УБГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ Н.Давааням, 2024.01.31-ны өдрийн Б/69 тоот тушаалаар ЗҮГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ Г.Анхбаяр, 2024.03.14-ний өдрийн Б/152 тоот тушаалаар ЭНСТ-ийн эрэлч нохойн сургалт хариуцсан ГУБ Т.Нандин-Эрдэнэ, 2024.03.14-ний өдрийн Б/151 тоот тушаалаар ЭНСТ-ийн Эрэлч нохойн сургалт хариуцсан ГУБ А.Энх-Амгалан, 2024.03.14-ний өдрийн Б/154 тоот тушаалаар ЧХОУНБГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ Г.Булган, 2024.03.14-ний өдрийн Б/184 тоот тушаалаар Ховд аймаг дах ГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ З.Буяннэмэх нар томилогдсон. Эдгээр эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч наарт 6 эрэлч нохдоор нөхөн хангарт хийж сургалтад хамруулан томилогдсон газар хороодод нь хүлээлгэн өгсэн.

- 2024 оны 1, 2, 3 сард 32 эрэлч нохдод, 5 сард 19 эрэлч нохдод үзлэг эмчилгээнд хамруулсан. Албаны эрэлч нохдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж шаардлагатай эм тариа туулгыг заасан хэмжээний дагуу ашиглаж

					байна. Харьяа гаалийн газар хороодын хяналт шалгалтад ашиглаж байгаа эрэлч нохдын арчилгаа болон хооллолт нохойд өдөр тутмын илчлэгийн хэмжээг тодорхойлж нохойн хоолны хэмжээг тодорхойлох тухай болон эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг тогтмол хугацаанд өгч ажиллаж байна. -2024 онд гаалийн албаны эрэлч нохойн сонголт, нөхөн хангарт, бүртгэлжилтийг зохицуулах журмын дагуу албаны эрэлч нохойн хөрөнгийн бүртгэлийн 4.7.-д Эрэлч нохойг биологийн насжилтаар нь 6-8 нас хүртэл ажиллуулж болно гэж заасан байdag. Гаалийн байгууллагын дансанд бүртгэлтэй байгаа эрэлч нохдын насанд судалгаа хийж үзэхэд 8 болон түүнээс дээш наслалттай 3 нохой байна. 2024 оны 3-р улиралд эдгээр 3 нохдыг данс бүртгэлээс хасуулах, 2022 оны үргжлийн хөтөлбөрийн дагуу шинээр бойжуулан авсан 4 гэлгийг данс бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох материалыг бүрдүүлж гаалийн ерөнхий газрын санхүү хөрөнгө, оруулалтын газар болон аж ахуй үйлчилгээний албандаа хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.		
2.	Албаны эрэлч нохойн үргүүлгийн талаар хийгдсэн ажил	Хэрэгжилт, гүйцэтгэл, тоогоор	-	-2024 онд албаны шаардлага хангасан, эрүүл чийрэг нохдыг сонгож	2024 оны үргжлийн хөтөлбөрт хамрагдах нохойг сонгоходоо ГЕГ-ын нийт данс бүртгэлд байгаа 48 нохойноос судалгаа авч үргжилд орох боломжтой 2-4 насны 19 ширхэг	01.01-06.05	50

				үржлийн хөтөлбөрийг боловсруулна -Үржлийн хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон нохойнуудыг нийллэгт оруулна.	нохой байснаас 15 нохой нь эр хүйтэй, 4 нохой нь эм хүйтэй байсан. Үүнээс ЭНСТ дээр 2-4 наасны 1 ширхэг эм нохой 4 ширхэг эр нохой байсан ч үүлдрийн хувьд таарахгүй болсон тул УХШИГГ-ын <b>Поло</b> дуудлагатай эм нохойг ЭНСТ-ийн <b>Коко</b> дуудлагатай эр нохойн хамт сонгосон. Үржлийн хөтөлбөрт хамрагдсан ноход өнгө зүс, үүлдэр, бие бялдар сайн мал эмнэлгийн үзлэгт тогтмол хамрагдсан товтолт вакцин, туулга бүрэн хийгдсэн. Тус ноход малын эмчийн хяналтад орж тогтмол үзлэг шинжилгээ хийгдэж байсан. 2024 оны 4-р сарын 22-ны өдөр эм нохойны ороо орж 7 дахь хоног буюу 4-р сарын 29-с 5-р сарын 1 хүртэл нийт 3 өдөр нийллэгт оруулсан боловч эм нохойны хувьд анхны нийллэг байсан тул хээл авч чадаагүй. Охин нохой хээл авч төрсөн цагаас эхлэн “Гаалын албаны эрэлч нохойн сонголт, нөхөн хангалт, бүртгэлжилтийг зохицуулах журам”-ын дагуу үзлэг оношлогоо, эмчилгээ, арчилгаа mallлагаа, албаны идэвх суулгах, нийгэмшүүлэх ажлууд хийгдэж эхлэнэ. 2024 оны 4-р улиралд дахин нийллэгт оруулахаар төлөвлөн ажиллаж байна.		
3.	Албаны чадамж бүхий эрэлч нохойн сургалт	Зохион байгуулсан сургалтын тоогоор	-	2 удаагийн эрэлч нохойн сургалт зохион байгуулна.	- 2024 оны эхний хагас жилд анхан шатны сургалт 3, давтан сургалт 1. Нийт 4 удаагийн эрэлч нохойн сургалтыг зохион байгуулж эрэлч нохойн сургалтын төвийн болон	01.01-06.05	100

гаалийн ерөнхий газрын харьяа 7 газар хороодын 13 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийг эрэлч нохойн хамт сургалтад хамруулсан. Үүнд:

1. 2024 оны 01 дүгээр сарын 02 ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 27 ны өдрийг хүртэл ажлын 42 хоног буюу 336 цагийн анхан шатны сургалтад СШГГ-ЭНХГУБ Б.Эрдэнэзул, ЧХОУНБГГ-ЭНХГУБ Ө.Өнөрчимэг, ДоГГ-ЭНХГУБ Б.Пунцагбал,
2. 2024 оны 01 дүгээр сарын 02 ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл ажлын 42 хоног буюу 336 цагийн давтан сургалтад ЧХОУНБГГ-ЭНХГУБ Б.Сарантуяа, УБГГ-ЭНХГУБ Р.Уянга, Э.Энхжин, УХШИГГ-ЭНХГУБ А.Отгонбаяр,
3. 2024 оны 02 дугаар сарын 05 ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 29 ны өдрийг хүртэл ажлын 40 хоног буюу 320 цагийн анхан шатны сургалтад УБГГ-ЭНХГУБ Н.Давааням, ЗүГГ-ЭНХГУБ Г.Анхбаяр.
4. 2024 оны 03 дугаар сарын 15 ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 16 ны өдрийг хүртэл ажлын 45 хоног буюу 360 цагийн анхан шатны сургалтад ЭНСТ-ЭНХГУБ А.Энх-Амгалан, Т.Нандин-Эрдэнэ, ЧХОУНБГГ-ЭНХГУБ

Г.Булган, ХоГГ-ЭНХГУБ  
З.Буяннэмэх нар тус тус  
эрэлч нохойн хамт  
хамрагдсан.

Сургалтад хамрагдсан эрэлч нохдын зорилтод үнэрүүдийг таньж, эрж олох чадвартайг болсоныг сургалтын зааланд тусгайлан зассан хэсэгт шалгаж тодорхойлсон. Эдгээр нохдыг гаалийн хяналт шалгалтад хэрхэн ашиглахыг тухайн газар хороодын холбогдох албадын хэрэгцээ шаардлагаас хамаарна.

- Албаны эрэлч нохойг 2013 онд гаалийн өрөнхий газрын дэд даргын баталсан сургалтын хөтөлбөрөөр явагддаг байсаныг сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор 2022 онос эхлэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд 2023 оны 02 сарын 03 ны өдөр “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл”-ийн №03 тоот тогтоолоор “Албаны нохой сургагч”, “Албаны нохой хөтлөгч”-ийн ажил мэргэжлийн стандартуудыг батлуулсан. Уг стандартуудыг дотоод гадаадын албаны нохойн сургалтын төвүүдийн сургалтын хөтөлбөрүүдтэй уялдуулан боловсруулж, хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам мөрдөх, тухайн ажлын байранд тавигдах ур чадвар, мэргэжлийн шаардлага, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хөдөлмөрийн нөхцөл, ажилтны гүйцэтгэх үүрэг, ажилбар, эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадамж, хандлага, дадлага, туршлага болон

холбогдох мэдээллийг агуулсан болно. Ажил мэргэжлийн стандартуудыг ашиглан гаалийн байгууллагын эрэлч нохдыг мансууруулах бодис таньж тогтоох чадварыг сайжруулах зорилгоор сургаж бэлтгэх сургалтын хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, судалгааны институттэй хамтран ажиллаж арга зүйч нараас зөвлөгөө мэдээлэл авч ажиллаж байна. 2023 оны 07 сарын 07 ний өдөр батлагдсан "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай" хууль батлагдаж түүний дагалдах журмууд батлагдах зэрэг шалтгаанаас болж албаны нохойн сургалтын хөтөлбөрт сургалтад ашиглах тухай дүгнэлт гаргах ажил түр хугацаанд зогссон.

Сургалтын хөтөлбөрт дүгнэлт гараагүй боловч Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2024 оны 04 сарын 03 ний өдрийн А/34 тоот тушаалаар эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б.Наранбадрах, эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч Н.Ганболд нар үнэлгээний ажилтан бэлтгэх сургалтад хамрагдаж албаны нохойн чиглэлээр мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөлтийн үнэлгээ зохион байгуулах эрхтэй болсон.

4.	Эрэлч нохой ашиглалтыг нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар, тоогоор	-	<p>-Хяналт шалгалтад ашиглаж байгаа эрэлч нохойн тоог 8-аар нэмэгдүүлнэ.</p> <p>Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нар сар бүр эрэлч нохой ашиглалтын мэдээг бэлтгэн гаалийн байгууллагын захиргаа, дотоод ажлын системд байршуулдаг. Уг мэдээг эрэлч нохойн сургалтын төвөөс сар бүр хүлээн авч эрэлч нохой ашиглалт болон зөрчил илрүүлэлтийг судалдаг. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 13 газар хороодод 33 эрэлч нохой ажиллаж 14 зөрчил илрүүлсэн. Үүнд: 1-р сард БӨГГ 1 зөрчил, 3-р сард ЧХОУНБГГ-1 зөрчил, СэГГ- 1 зөрчил, 4-р сард ЗүГГ-2 зөрчил, СэГГ- 1 зөрчил, ДоГГ- 2 зөрчил 5-р сард ЗүГГ- 1 зөрчил, СэГГ- 3 зөрчил нийт 14 зөрчил илрүүлээд байна. Энэ нь 2023 оны эхний хагас жилийн байдалтай харьцуулан үзэхэд 55.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эрэлч нохдын зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх, гаалийн хяналт шалгалтад ашиглах эрэлч нохдыг нэмэх зорилгоор хориглосон хязгаарласан бараа бүтээгдэхүүн, хар тамхи мансууруулах бодис зэргийг таньж илрүүлэх ЭНСТ-ийн анхан болон давтан сургалтуудад хамрагдаж бэлтгэгдсэн 11 нохойгоор нэмэгдүүлсэнээр 33 эрэлч нохойтой болсон. Үүнд: ЧХОУНБГГ-т 3 нохой, ДоГГ-т 1 нохой, СшГГ-т 1 нохой, ЗүГГ-т 1 нохой, УБГГ-т 2 ЭНСТ- 3 нохойгоор тус тус нөхөн хангарт хийсэн. Мөн албаны нохойн ажлын бүтээмжид шууд нөлөөлөх эрэлч</p>	01.01-06.05	100

				ноходдод шаардлагатай амин дэм эрдэс витаминаар баялаг зориулалтын үйлдвэрийн хоол, эрүүл мэндэд шаардлагатай эм тариа зэргийг газар хороодод тараасан.		
5.	Бусад байгууллагатай хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэээр	-	<p>Гадаадын болон дотоодын нохой сургалтын төвүүдтэй туршлага солилцно.</p> <p>- Тайлант хугацаанд гадаадын нохой сургалтын төвүүдтэй 1 удаа туршлага солилцсон, 1 удаа эрэлч нохойг захиалга дуудлагаар ашигласан, хамтарсан ажилд 1 удаа оролцсон. Үүнд:</p> <p>1. Дэлхийн гаалийн байгууллагаас 2024 оны 3 дугаар сарын 5-наас 7-ний өдрүүдэд Хонгконг улсад эрэлч нохойн 6-р чуулга уулзалтыг зохион байгуулсан. Хуралд Монгол Улсын гаалийн байгууллагыг төлөөлөн эрэлч нохойн сургалтын төвөөс Б.Наранбадрах, Н.Ганболд, И.Солонго нар оролцсон. Чуулга уулзалтад 47 орны гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвүүдийн удирдлага, сургалт хариуцсан ажилтан, сургагч багш нар зэрэг 80 орчим төлөөлөгч нар оролцож өөрсдийн нохой сургах туршлага, ашиглалт, үргүүлгийн талаар танилцуулсан. Монгол Улсын гаалийн байгууллага нь -35 градусаас +35 градусын хооронд нохойг сургаж бэлтгэн албандаа ашиглаж чадаж байгаа нь сайн туршлага гэж хурал зохион</p>	01.01-06.05	100

байгуулагч нар дүгнэсэн. Чуулга уулзалтад оролцож туршлага солилцсон талаарх тайланг бусад албан хаагч нарт мэдээлэл хүргэх зорилгоор гаалийн байгууллагын захиргаа, дотоод ажлын системийн гадаад арга хэмжээ дэд хэсэгт 2024 оны 03 сарын 21 ны өдөр “ДГБ-аас Хонгконг улсад зохион байгуулсан эрэлч нохойн сургалтад оролцсон тайлан” нэртэйгээр байршуулсан.

2. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газраас 2024 оны 05 дугаар сарын 13 ний өдрийн № 01/144 тоот албан бичгээр тус газрын эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч А.Огтонбаярын ээлжийн амралтын хугацаа дуустал эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийг түр ажиллуулж өгөх хүсэлтийг ирүүлсэн. Хүсэлтийн дагуу эрэлч нохой сургалтын төвийн гаалийн улсын байцаагч А.Энх-Амгалан, Т.Нандин-Эрдэнэ нар түр хугацаагаар улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын хяналт шалгалтын үйл ажиллагааг эрэлч нохойгоор дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

3. Цагдаагийн ерөнхий газрын тээврийн цагдаагийн албаны

					иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсээс гаалийн ерөнхий газрын дэд даргад 2024 оны 06 дугаар сарын 04 ны өдрийн 13-4/349 тоот албан бичгээр хандаж Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны 05 дугаар сарын 28-ны өдрийн “Эргүүл ажиллуулах тухай” А/226 дугаар тушаалын дагуу “Чингис Хаан” Олон Улсын нисэх буудалд 2024 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүлгийн эргүүл ажиллуулах болсонтой холбогдуулан албаны нохой байрлуулах түр байраар хангаж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах тухай хүсэлтийг гаргасан. Хүсэлтийг эрэлч нохойн сургалтын төвд шилжүүлж 2024 оны 06 дугаар сарын 04 ний өдрөөс эхлэн цагдаагийн албаны эрэлч нохойг малын эмчийн үзлэгт хамруулан гаалийн албаны эрэлч нохойн үүрэнд байрлуулсан.	
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний	Тайлант хугацаанд Эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгт хамааралтай бодлогын баримт бичгүүд байгаагүй тул хэрэгжилтийг	01.01-06.05 100

				хэрэгжилтийг тайлагнана.	тайлагнаагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийг ханган ажиллаж, хугацаанд нь тайлагнах болно.		
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Холбогдох хууль тогтоомж эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллана.	<p>-Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаа, чиг үүрэгт холбогдох гаалийн ерөнхий газрын даргын баталсан дотооддоо дагаж мөрдөх эрх зүйн 7 акт, Монгол Улсын хууль тогтоомжуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол дагаж мөрдөж ажилласан байна. Мөн бусад Монгол улсын хууль журам болон гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан нийтээр болон дотооддоо дагаж эрх зүйн актуудын хэрэгжилтийг тодорхой тохиолдолуудад дагаж мөрдөж ажилласан.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/181 тоот журмын хэрэгжилтийг хангаж эрэлч нохдыг бүртгэл тооцоонд авах, бүртгэлээс хасах, хяналтын карт болон хувийн хэргийн тэмдэглэлийг тогтмол хийж байна.</p> <p>-2024-02-05-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/107 тоот тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байпал, эрүүл ахуйн нийтлэг зааварчилгаа”-ны хэрэгжилтийг ханган албан хаагчдад танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан.</p> <p>- 2024-03-20-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 08 сарын 23 ний өдрийн А/176 тоот</p>	01.01-06.05	100

тушаалаар батлагдсан "Эрэлч нохойн сургалтын төвийн дүрэм"-г 7 албан хаагчдад гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

- 2024-03-26-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 10 сарын 24 ний өдрийн А/226 тоот тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-г 8 албан хаагчдад танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

-2024-04-05-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/204 тоот тушаалаар батлагдсан "Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам"-г 4 албан хаагчдад гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

-2024-04-08-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/69 тоот тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын журам" "-г 4 албан хаагчдад гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

-2024-04-17-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 07 сарын 28 ний өдрийн А/181 тоот тушаалаар батлагдсан " Гаалийн албаны эрэлч нохойн сонголт, нөхөн хангарт, бүртгэлжилтийг зохицуулах

				журам""-г 4 албан хаагчдад гарын үсэг зуруулан баталгаажуулсан.  -2024-04-25-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/271 тоот тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын бэлгэ тэмдгийн тухай журам" "-г 4 албан хаагчдад гарын үсэг зуруулан баталгаажуулсан.		
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, эрсдэлийг таньж тогтооно.	-Эрэлч нохойн сургалтын төв нь Төв аймгийн Сэргэлэн суманд Улаанбаатар хотоос 50 орчим км здтай байрладаг ба ажилчид ажилдаа ирж очиждоо хамгийн холдоо 118 км зам туулж сард 44 удаа/өглөө, орой/ явж байна. Эрэлч нохойн сургалтын төвийн зүүн талаас ирдэг автозам нь Дундговь, Өмнөговь аймаг руу явдаг гол зам учир том оврын тээврийн хэрэгсэл ихээр зорчдог үүнээс болж зам тээврийн осол их гардаг, зүүн талаас ирдэг зам Чингис Хаан Олон Улсын нисэх буудлаас хүн тосох, үдэж өгөх шалтгаантай тээврийн хэрэгслийн хөдөлгөөн их байдаг нь мөн зам тээврийн осол гарахад нөлөөлдөг. Дээрх 2 замаар тогтмол хувийн тээврийн хэрэгслээр зорчдог албан хаагч нараас эрсдэл тооцон	01.01-06.05	100

ярилцлага хийхэд Улаанбаатар хотоос болон Төв аймаг, Өлзийт хороололоос эрэлч нохойн сургалтын төвийн байрладаг газар луу явдаг нийтийн тээвэр, хот хоорондын тээвэр байдаггүй, ЧХОУНБГГ-ын ажилчдын автобусаар зорчих боломж байгаа ч ажлын нөхцөл байдал, онцлогоос шалтгаалан тухайн автобусанд ажил тарах үеэр сууж амждаггүй, зарим тохиолдолд багтдаггүй зэрэг шалтгаанаас болж албан хаагч нар гол төлөв хувийн унаагаар зорчиж байгаа хариулт өгсөн. Албан хаагч нарыг эрдэлээс урьдчилан сэргийлэх болон амь насыг хамгаалах үүднээс 2024 оны 05 дугаар сарын 22 ны өдрийн №2024/34 тоот дотоод зурвасаар гаалийн ерөнхий газрын санхүү, хөрөнгө оруулалтын газар болон аж ахуй, үйлчилгээний албанад “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.5, 11.6 дахь заалтуудыг үндэслэн амь насны даатгалд үнэ төлбөргүй хамруулах хүсэлтийг хүргүүлсэн.

-ЭНСТ-ийн нийт ажилтан албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэх, эрэлч нохойтой ажиллахдаа бэртэж гэмтэх, нохойд хазуулах гэх мэт эрсдэлтэй байдаг тул Гаалийн

					ерөнхий газрын даргын А/107 тоот тушаал “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг зааварчилгаа”-ны дагуу өдөр бүр аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулан авч байна.		
9.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллана.	-2024 эхний хагас жилийн байдлаар гаалийн байгууллагын захиргаа дотоод ажлын системийн үүрэг даалгавар дэд цэсээр дамжуулан гаалийн ерөнхий газрын захиргааны удирдлагын газраас 2 үүрэг даалгаар, хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 8 зөвлөмжийг өгсөн. Захиргаа удирдлагын газраас өгөгдсөн 1 үүрэг даалгаварын хугацаа 4-р улиралд дуусах тул биелэлтийг оруулаагүй, бусад 8 зөвлөмж болон 1 үүрэг даалгаварын биелэлтийг тайлагнасан. Үүнээс 1 үүрэг даалгавар, 7 зөвлөмжийг холбогдох газруудаар дүгнүүлж, 1 үүрэг зөвлөмж илгээсэн төлөвтэй хүлээгдэж байна. Үнэлүүлсэн үүрэг даалгавар болон зөвлөмжийн биелэлтийн дундаж хувь 100 байна.	01.01-06.05	100
10.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, оноогоор	-	Албан хаагч нарын ажлын цаг ашиглалт бүрэн байна.	-2024 оны эхний 5 сарын байдлаар төрийн тусгай албан хаагч 6, төрийн үйлчилгээний албан хаагч 9, нийт 15 албан хаагчтайгаар ажиллаж байна. 1 албан хаагч 2024 оны 1-р сард 176 цаг, 2-р сард 160 цаг, 3-р сард 160 цаг, 4-р сард 176 цаг, 5-р сард 176	01.01-06.05	100

					цаг нийт 848 цаг ажилласан. Ажиллах хугацаанд ажил тасалсан албан хаагч байхгүй. Эрэлч нохойн сургалтын төвийн албан хаагч нарын ажилдаа ирэх, тарах цагийг өдөр тутам тогтмол бүртгэж сард 2 удаа нэгтгэж гаалийн ерөнхий газрын аж ахуй, үйлчилгээний албандаа хүргүүлдэг. Ажлын цаг ашиглалт 100 хувь.		
11.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Харьяа гаалийн газар, хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдад заавар, зөвлөмж өгнө. Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр ГУБ нарыг үнэлгээний сургалтад хамруулна.	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 03 ны өдрийн A/34 тоот тушаалаар үнэлгээний ажилтан бэлтгэх сургалтад ГЕГ-ын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б.Наранбадрах, гаалийн улсын байцаагч Н.Ганболд нар амжилттай хамрагдаж, үнэлгээний арга зүйг эзэмшин үнэлгээний ажилтны гэрчилгээ, үнэмлэх авсан.</li> <li>- 2024 онд эрэлч нохойн сургалтын төвөөс гаалийн улсын ахлах байцаагч Я.Мөнхнасан 2 ажлын хэсэгт орж ажилласан. Үүнд:           <ol style="list-style-type: none"> <li>1. Гаалийн ерөнхий газрын даргын 2024.03.22-ны өдрийн № A/185 тоот “Үнэлгээний хороо байгуулах” тушаалаар эрэлч нохойн сургалтын төвийн Гаалийн улсын ахлах байцаагч Я.Мөнхнасан үнэлгээний хорооны даргаар ажиллаж гаалийн байгууллагын эрэлч нохдын хэрэгцээнд зориулалтын хоол нийлүүлэх харьцуулсан тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах</li> </ol> </li> </ul>	01.01-06.05	100

ажлыг зохион байгуулсан. tender.gov.mn цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр тендерийн урилгыг байршуулж 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр тендерийн нээлтийг хийсэн. Энэхүү үнэлгээний ажлыг холбогдох хууль дүрмийн дагуу зохион байгуулж материал ирүүлсэн аж ахуй нэгжээс “Аз болор мөнх трейд” ХХК шаардлага хангагдан сонгогдож нохойн хоолны хангалт 100% хийгдэж ГЕГ-н харьяа гаалийн газар хороод дахь эрэлч нохдод хоолны хангалт хийгдэж амжилттай ажилласан.

2. Гаалийн ерөнхий газрын даргын 2024.02.01-ны өдрийн № А/103 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар эрэлч нохойн сургалтын төвийн гаалийн улсын ахлах байцаагч Я.Мөнхнасан ажлын хэсэгт гишүүнээр орж ажилласан. Тус ажлын хэсэг нь Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбогдуулан гаалийн ерөнхий газрын нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын удирдах гүйцэтгэх төрийн тусгай ангиллын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах зорилготойгоор холбогдох судалгааны ажлуудыг хийн ажиллаж байна.

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үндэсний мод тарих өдөртэй холбогдуулан гаалийн ерөнхий газрын албан хаагч нарын мод тарих ажлыг зохион байгуулах.	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Үндэсний мод тарих өдөртэй холбогдуулан мод тарих ажил зохион байгууллагдсан байна.	Гаалийн ерөнхий газрын удирдлагын зүгээс үүргийн дауу үндэсний мод тарих өдөртэй холбогдуулан гаалийн байгууллагын албан хаагч нарын мод ажлыг 2024 оны 05 дугаар сарын 18 ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын 4-р баг хөшигийн хөндийд байрлах гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн хашаанд зохион байгуулсан. Арга хэмжээнд Гаалийн ерөнхий газар, улаанбаатар хот дахь гаалийн газар, улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газруудын 100 гаруй албан хаагч гэр бүлийн хамт оролцож 200 орчим мод тарьсан. Тарьсан модыг арчилах, услах ажлыг эрэлч нохойн сургалтын төв хариуцан хийж байна. Арга хэмжээг гаалийн байгууллагын цахим худсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. <a href="#"><u>ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА</u></a> <a href="#"><u>ТЭРБУМ МОД ТАРИХ</u></a> <a href="#"><u>АЯНД НЭГДЛЭЭ – Гаалийн</u></a>	01.01-06.05	100

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Сургалтад хамрагдсан байна.	-Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 03 ны өдрийн А/34 тоот тушаалаар “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/513, А/171 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган чадамжийн үнэлгээг хийх эрх бүхий үнэлгээний ажилтан бэлтгэх хамрагдаж төгссөн. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институттээс	01.01-06.05	100

					хөтлөгч, албаны нохой сургагч чиглэлээр ажиллах үнэлгээний ажилтаны эрхийг баталгаажуулж гэрчилгээ, үнэмлэх олгосон. -Улаанбаатар эрдэм их сургуульд “Бизнесийн удирдлага”-ын чиглэлээр магистрын зэрэг олгох сургалтад 2022 оноос эхлэн суралцсан. 2024 оны 05 дугаар сард төгсөлтийн шалгалтуудыг өгч тэнцсэн. Улаанбаатар эрдэм их сургуулийн ректорын 2024 оны 06-р сарын 04-ний өдрийн №58 тоот тушаалаар № 7202402114 дугаартай дипломоор Бизнесийн удирдлагын магистрын зэрэг олгосон.	
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, албан хаагчдад танилцуулж өдөр тутмын үйл ажиллагаандaa нэвтрүүлсэн байна.	-Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж дэргэдэх байгууллагуудаас дотоод зурvasaар ирсэн хууль, журмын төсөл хөтөлбөрүүдтэй тогтмол танилцаж, эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгт хамаарах хууль, дүрэм, журамд тогтмол санал хүргүүлэн ажилласан. Гаалийн ерөнхий газрын даргын баталсан дотооддоо дагаж мөрдөх эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангах үүднээс тогтмол бие даан судалж, өөрийн нэгжийн	01.01-06.05 100

				албан хаагч нарт танилцуулан ажилласан.		
--	--	--	--	--	--	--

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Эрэлч нохойн сургалтын төвийн  
дарга  
( Албан тушаал )

Б.Наранбадрах /...../  
( Нэр, гарын үсэг )

2024. 6. 10  
( Огноо )

**ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Я.МӨНХНАСАНГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС  
ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар  
Нэгжийн нэр: Эрэлч нохойн сургалтын төв

**1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1	2	3	4	5	
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

Зорилт 1."Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1.	Албаны эрэлч нохойн амьдрах, сургах орчин нөхцөлийг сайжруулсан байдал	58	10	68	
2.	Албаны эрэлч нохойн үргүүлгийн талаар хийгдсэн ажил	48	8	56	
3.	Албаны чадамж бүхий эрэлч нохойн сургалт	60	10	70	
4.	Эрэлч нохой ашиглалтыг нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ	55	10	65	
5.	Бусад байгууллагатай хамтран ажилласан байдал	60	10	70	
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	60	10	70	
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	
9.	Үүрэг даалгаврын биелэлт	60	10	70	
10.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
11.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	60	10	70	

**2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	2	3	4	
1.	Төрийн хуулийн албаны тухай 29.1-т заасан богино болон дунд сургалтад хугацааны хамрагдах	86	13	
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	86	13	
Дундаж оноо:		13		

**3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)**

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	2	3	
1.	Хандлага, ёс зүй	2	
2.	Асуудал шийдвэрлэх	7	
3.	Хариуцлагатай байдал	6	
4.	Дүн шинжилгээ хийх	7	
5.	Ажлын цаг ашиглалт	6	
Дундаж оноо:		6.4	

**4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)**

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
1.	2	
1.	Хандлага, ёс зүй	2
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	7
Дундаж оноо: 7.6		8

**5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**


Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлттүүрэг даалгаавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	68

2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.4
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7.6
5.	Үнэлгээний оноонд орсон веерчлэлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
<b>Нийт оноо =</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) ) Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		95

**Үнэлгээ өгсөн:**

**Нэгжийн дарга**

Эрэлч нохойн сургалтын төвийн дарга

(Б. Наранбадрах)


2024-06-10 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

**зөвшөөрсөн:**

Гаалийн улсын ахлах байцаагч

(Я. Менхнасан)


2024-06-10 (огноо)

**Үнэлгээг хянасан:**

**Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:**

Дэд даргын албан үүргийг түр

орлон гүйцэтгэгч


(Г. Энхтайван)

2024.07.26 (огноо)

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч

(Ж. Баясгалан)

(огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан:**

**Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга

(Р. Отгонжаргал)

(огноо)